



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and  
Competitiveness Project

# ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 4 дүгээр сар

## Замын-Үүдийн ложистик төвийн талаар хийсэн урьдчилсан дүн шинжилгээний дүнг танилцуулав

учирч буй нийт зардал маш өндөр юм. Энэ нь бараа нийлүүлэлтийн хомсдол, үнийн хөөрөгдлийг бий болгож, албан бусаар төлбөр төлөх нөхцөлийг бүрдүүлж байгаагаас гадна дэлхийн хандлагыг даган тэгтээ тэргүй нэмэгдэж буй үнийн өсөлтөд нэмэлт дарамт болж байгаа аж.



4 дүгээр сарын 22-нд болсон хувийн хэвшил, олон улсын төлөөлөгчдийг оролцуулсан Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хорооны (ХТХҮХ) өргөтгөсөн хуралдаан дээр Замын-Үүдийн ложистик төвийн талаар хийсэн урьдчилсан дүн шинжилгээний дүнг төслийн зүгээс танилцууллаа. Олон улсын ложистикийн эксперт Майкл Бенет уг төслөөс зохион байгуулсан судалгааны багийг тэргүүлсэн болно.

Товчдоо, Замын -Үүд дэх ложистик төвийн дэд бүтцийн шаардлага хангахгүй байгаа байдал нь бараа нийлүүлтэд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлт, худалдан авах чадвар нэмэгдэхийн зэрэгцээ Монгол улсын эдийн засагт инфляцийн дарамт бий болоход нөлөөлж байна.

Судалгааны дүн Гааль ба Улсын мэргэжлийн хяналтын газруудын (УМХГ) Замын -Үүд дэх хяналтын ажиллагааны нөхцөл байдалд чиглэгдэж, авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих шинэ ложистик төв барих саналыг судалгаанаас гаргав.

### Замын -Үүд дэх Гааль, мэргэжлийн хяналтын ажиллагааны нөхцөл байдал

Өнөөгийн тээврийн хөдөлгөөнийг зохицуулж, эдийн засгийн

### Зураг 1: Замын -Үүдийн Гааль, мэргэжлийн хяналтын талбайн өнөөгийн байдал (сансрын зураг)

### Өнөөгийн нөхцөл байдал

Тус төслийн зүгээс энэ оны 4 дүгээр сарын 14-19 өдрүүдэд ачааны машины 550 жолооч нарын дунд хийсэн судалгаагаар Монголын хамгийн том гарц болох "хуурай газрын боомт" дээр байдал хүндрэлтэй байна. Хүлээлгийн дундаж цаг дараах байдалтай байна:

- Холимог ачааг хяналт шалгалтаар оруулах болон хүлээлгэнд 23.5 цаг
- Ижил төрлийн ачааг хяналт шалгалтаар оруулах болон хүлээлгэнд 28.2 цаг
- Ачааг машинаас төмөр зам руу шилжүүлэн ачих болон хүлээлгэнд 135 цаг
- Хятадад ачаа ачуулснаас эхлэн Замын үүдэд жинлүүлж дуустал 34.2 цаг тус тус шаардагдаж байна.

Хэдийгээр Замын -Үүдийн тээврийн хөдөлгөөний хувьд 4 дүгээр сар "ачаалалтай үе" биш боловч энэхүү дарааллаас




Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

өсөлтийг хөхиүлэн дэмжихэд Замын -Үүд дэх хяналтын ажиллагааны нөхцөл шаардлага хангахгүй байна. Энэ нь "Транзит Монгол" үндэсний хөтөлбөрт санал болгосны дагуу Хятад, Европын хооронд өрсөлдхүйц транзитын коридор болох гэсэн Монголын хүсэл эрмэлзэлд учирч буй бэрхшээлүүдийн нэг билээ.

Зураг 1-д Замын -Үүдийн Гааль, мэргэжлийн хяналтын талбайн одоогийн байдлыг сансраас авсан зургаар харуулсан болно.

Зураг 2-т цаашид хийх өөрчлөлт шинэчлэлийн төлөвлөгөөг харуулсан болно. Үүнд

**Зураг 2: Замын -Үүд дэх хилийн хяналтын ажлыг сайжруулах талаар гаргаж буй санал**



- Ачааны машины эргэлт, хяналт шалгалтын ажлыг хөнгөвчлөх нөхцлийг сайжруулах
- Зорчигч тээврийг ачаа тээврээс тусгаарлах
- Ачааны төрлөөр ачаа тээврийг салгах: ижил төрлийн ачааг рентгенээр шууд шалгах, холимог ачааг хяналтын талбай руу явуулах

Урьдчилсан тооцоогоор Гааль, мэргэжлийн хяналтын талбайг өргөтгөхөд 2.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай, нэг ачааны машинд зарцуулагдах нэг өдрийн дундаж зардал 37 ам.доллар, бараанд зарцуулах өдрийн дундаж зардал 7 ам.доллар байна гэж үзвэл Эдийн засгийн дотоод өгөөжийн коэффициент (ЭЗДӨК) - нийт эдийн засагт үзүүлэх ашиг- 200 хувиас дээш байна гэсэн тооцоо гарчээ.

Уг төслийн зүгээс хяналтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөн шинэчлэх талаар Гаалийн ерөнхий газар (ГЕГ- санал болгож буй төслийг удирдан чиглүүлэх байгууллага), Улсын мэргэжлийн хяналтын газарт (УМХГ) туслалцаа дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ. Одоогийн байдлаар шинээр барих ложистик төвийн зураг төслийг гаргаж, барилга байгууламжийн техникийн шаардлагыг боловсруулах ажлуудыг төлөвлөөд байна. ГЕГ тендерийг зарлаж, иргэний барилга байгууламжийн барилгын ажлыг удирдан ажиллана.

**Авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих шинэ терминал**

Хил дээр барааг хянаж шалгасны дараа авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих шинэ терминал шаардлагатай байгаа нь тодорхой. Энэхүү байгууламжийн урт хугацааны хөгжлийг хангахын тулд дор хаяж 200 га шинэ газар талбай шаардлагатай.

Авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих санал болгож буй шинэ терминалын байршил нь Замын -Үүдийн "хүндийн төв"-ийг өөрчлөх тул дараах зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:


- 400 га газрыг нөөцөнд авах, шинэ терминал барих төлөвлөгөө гаргахын сацуу газар ашиглалт, бүсчлэлийн мастер төлөвлөгөө боловсруулах
- Замын-Үүдэд авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих шинэ терминал барих төлөвлөгөө болон санал болгож буй шинэ терминалын эргэн тойрны газар ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд орон сууцны бус зорилгоор газар эзэмших эрх олгох асуудлыг түр зогсоох

Эдгээр зөвлөмжүүд нь хотын дэд бүтцийг сайжруулахад тус дөхөм болох зохистой төлөвлөлт, хөрөнгийн тооцоог гаргах боломжийг бий болгохоос гадна хотын захиргааны орлогыг бүрдүүлэхэд газар эзэмших эрх олгох нээлттэй тогтолцоог бий болгох нөхцлийг бүрдүүлнэ. Жишээлбэл хилийн чанд дахь Хятадын Эрээн хотын захиргаа шинэ газар барьж, хотжуулахдаа хувийн хэвшлийнхэнтэй түншилж хамтарч ажилладаг байна. Хувийн хэвшлийнхэн шинэ газрыг барьж, дараа нь тухайн газрыг борлуулснаас олсон орлогын тодорхой хувийг хотын захиргаандаа төлдөг аж.

Хуралд оролцсон хандивлагчид ба янз бүрийн байгууллагын төлөөллүүд Замын-Үүдийн мастер төлөвлөгөөг боловсруулахад туслалцаа үзүүлэх сонирхолтой буйгаа илэрхийллээ. Хил дамнанас худалдааг хөнгөвчлөх төслийн хүрээнд мастер төлөвлөгөө боловсруулахад Азийн Хөгжлийн Банк Замын-Үүдийн захиргаанд туслалцаа үзүүлэх боломжтой юм байна.

Зураг 3-т авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих санал болгож буй шинэ терминалын концепци, барих үе шатыг харуулсан болно.

**Зураг 3: Замын -Үүд дээр авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих ложистикийн шинэ терминал барих үе шат (санал)**



Илүү нарийвчилсан судалгаа хийгдэх хүртэл одоогийн урьдчилсан байдлаар энэхүү байгууламжийг барьж дуусгахад 120 сая ам.доллар шаардагдах тооцоотой байна. Уг байгууламжийн үйл ажиллагааны эхний шатны зардал болох ложистик төвийн агуулахуудыг барихад ойролцоогоор 5 сая ам.доллар шаардлагатай гэсэн тооцоо гарчээ.

**Төр, хувийн хэвшлийн боломжит түншлэл**

Авто замаас төмөр зам руу шилжүүлэн ачих ложистик төв, терминал барих санал болгож буй төсөл нь маш өргөн цар хүрээтэй (+/-170 га газар шаардлагатай), янз бүрийн

зориулалттай (төмөр зам, авто зам, агуулах/түгээх/нэмэгдсэн өртөг), өртөг өндөртэй төсөл юм. Үүнээс гадна энэхүү төсөл нь төрийн бодлого, зохицуулалтын бүрэлдэхүүн хэсгийг агуулахын зэрэгцээ (газар, хөрөнгө хувиарлалт; эдийн засгийн ба бүсийн хөгжил; гаалийн баталгаат үйл ажиллагаа), цэвэр арилжааны янз бүрийн боломжуудыг (одоо хэрэгжиж буй бизнесийн гол чиглэлүүд мөн бие даасан бизнесийн шинэ аж ахуйн нэгжүүдийг хөхиүлэн дэмжих) багтаах бөгөөд үүнд үүсгэн байгуулах зардал гэх мэт зардал орж болох юм.

Хэтийн янз бүрийн төлвүүд, оролцогч талуудын зорилтууд энэхүү санаачлага дор нэгдэж буй нь энэ төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэл загвараар хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байж болохыг харуулж байна. Хэрэв бүх оролцогч талууд хамтран ажиллаж чадвал тэд тус бүрдээ өөрийн зорилгод хүрч, төслийн үр дүн илүү өгөөжтэй байж болох юм.

Төр, хувийн хэвшлийн энэхүү бүтэц нь ( энэ нь магадгүй одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд тусгай зориулалт бүхий нэгж байж болох юм) хотын захиргаа (газар), УБТЗ ба Монголын Төмөр зам гэх мэт улсын салбарыг хамарч болох юм. Хувийн хэвшилд тээвэр, зуучийн компаниуд, гадаадын стратегийн боломжит хөрөнгө оруулагчид, гүйцэтгэгч байгууллагууд багтана. Иймэрхүү загварын түншлэлийг бий болгоход хөрөнгө оруулахад бэлэн буйгаа монголын тээвэр, зуучийн компаниуд илэрхийллээ. Энэхүү хэтийн зорилтыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудад төслийн зүгээс цаашид туслалцаа дэмжлэг үргэлжлүүлэн үзүүлсээр байх болно.

## Сэтгүүлчид Дарханы Дулааны цахилгаан станцад зочлов

Энэ оны 4 дүгээр сарын 25-нд Өдрийн сонин, Зууны мэдээ, Улаанбаатар Таймс, МОНЦАМЭ, Монголын Үндэсний Радио, хоёр FM радиог төлөөлсөн 11 сэтгүүлч Дарханы Дулааны цахилгаан станцад зочилж, тус станцын одоогийн нөхцөл байдал, үйл ажиллагаа, станцыг шинэчлэн сэргээх цаашдын төлөвлөгөөтэй танилцлаа. Уг станцын дэд захирал бөгөөд ерөнхий инженер ноён Г.Туяахүү, Инженерийн газрын дарга ноён Б.Амсарваа, Санхүүгийн хэлтсийн дарга Ц.Ууганбаяр нар сэтгүүлчдэд товч мэдээлэл хийж, тэдний тавьсан асуултанд хариу өгөв.



48 мВт хүчин чадалтай Дарханы ДЦС нь Монголын эрчим хүчний хэрэгцээний 19 хувийг хангадаг билээ. Уг станц нь байгуулагдсанаасаа хойш 40 гаруй жилийн туршид тогтмол үйл ажиллагаа явуулж, Дархан хот болон Дархан-Сэлэнгийн

бүсийг нийтэд нь дулаан, цахилгаанаар хангадаг. Дархан нь Монгол улсын хоёр дахь том хот бөгөөд ашигт малтмалын нөөцөөр баялаг, газар тариалан, төмрийн үйлдвэр эрчимтэй хөгжсөн газар юм.

Станцын удирдлага, ажилтнууд дараах нэн чухал гурван асуудлыг онцлож байв: нөхөн сэргээлт буюу засвар үйлчилгээ, санхүүгийн алдагдал, нүүрсний хангамжийн асуудал. Байнга нэмэгдэж буй зардлаа нөхөхөд станцын орлого хангалтгүй байгаа тул дээрх асуудлууд хоорондоо нягт уялдаа холбоотой. Шаардлагатай бүх зардлаа нөхөх хангалттай орлогыг станц хуримтлуулж чадахгүй байгаа бөгөөд төрөөс эрчим хүчний үнийг тогтоож буй нь алдагдал бий болж байгаагийн гол шалтгаан гэж станцын ажилчид үзэж байв. Тарифыг нэмэх нь станцын санхүүгийн байдлыг сайжруулахад тус дөхөм болж чадна.

Гэхдээ өгсөн бүх мэдээллүүд тааруу мэдээлэл байсангүй. Нэмэлт цахилгаанаар илүү үр ашигтай хангах үүднээс турбины шинэ генератор худалдан авч, суурилуулахад зориулагдсан хөнгөлттэй зээлийг Германаас авахаар станцын удирдлага саяан тохиролцжээ (УИХ баталсан). Үүнээс гадна төсвийн санхүүжилт болон өөрийн хөрөнгөөр нэг зуухыг засварлаж, шинэчлэх ажлыг дуусгасан бөгөөд 2008 оны 7 дугаар сард хоёр дахь зуухыг засварлан дуусгахаар ажиллаж байна. Иймэрхүү арга хэмжээ нь станцын бүтээмжийг сайжруулахаас гадна нүүрсний шаардлагатай хэмжээг бууруулж, орчинд үзүүлэх нөлөөг багасгах юм. Үүний сацуу дулааны шугамыг засварлан, өргөтгөх ажил мөн өрнөж байна.

Нөгөөтэйгүүр нүүрсний хангамжийн асуудал ноцтойгоор тулгараад байна. Шарын голын уурхай (станцаас 70 км зайд оршдог) станцыг нүүрсээр хангадаг боловч сүүлийн үед нүүрсний үнээ нэмнэ гэж айлгаж байгаа нь Дарханы ДЦС-ын санхүүгийн байдалд хүндрэл учруулж байгаа аж. Шарын голын уурхайн хүндрэлтэй байдал нүүрсний хангамж буурахад нөлөөлж байгаа учраас станц одоо нүүрсээ 350 гаруй км зайд байдаг Багануураас худалдан авах болоод байна. Станцын зуухууд Шарын голын уурхайн нүүрс ашиглахад зориулагдсан тул тухайлбал зуухны бүтээмжийн хувьд техникийн хүндрэл гарч, түлшний хэрэглээний үнэ нэмэгдэхэд нөлөөлж байгаа аж.

Аюулгүй байдлын талаар тавьсан асуултад аюулгүй байдлын хувьд станц маш сайн нөхцөлд байгаа гэж станцын удирдлага хариуллаа. Гэсэн хэдий ч ажилчдын цалин бага байгаа нь өндөр цалинтай төмрийн үйлдвэрт ажилчдаа алдахад нөлөөлж байна гэв.

Дарханы ДЦС-д хийсэн энэхүү уулзалт нь Түлш, эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах газрын хооронд өнгөрсөн зун уг төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн олон нийтийн боловсролыг дээшлүүлэх кампанит ажлын нэг хэсэг юм. Энэхүү арга хэмжээний дараа 15 хэвлэлээр Дарханы ДЦС-т хийсэн уулзалтын талаар нийтлэл гарч, телевиз, радиогоор шинэ нэвтрүүлэг дамжуулсан болно.

**Монгол улсыг зорчих улс орноор сурталчлах талаар ҮАЖБ-аас гаргасан саналыг хэлэлцэхээр аялал жуулчлалын салбарынхан хурал цуглалаа**



2008 оны 4 дүгээр сарын 4-ий өдөр төрийн бус Үндэсний аялал жуулчлалын байгууллага (ҮАЖБ) хийсэн ажлаа байгууллагынхаа гишүүд, аялал жуулчлалын салбарынханд тайлагнаж, Монгол улсыг Хойд Америк, Европын зах зээл дээр зорчих улс орноор сурталчлах чиглэлээр цаашид хийх ажлынхаа талаар танилцууллаа. Брау хаус ресторанд зохион байгуулсан уг арга хэмжээнд тур оператор, зочид буудал, жуулчны гэр бааз, хөтөч-тайлбарлагчдын төлөөлөгчид оролцсоноос гадна аялал жуулчлалын төрийн бус байгууллага, Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны төлөөлөгчид хүрэлцэн ирсэн байв.

ҮАЖБ-аас дараах саналуудыг танилцуулав. Үүнд:

- Одиссей хэвлэлийн компанитай хамтран 600 хуудастай Монголын тухай жуулчны гарын авлага, ном гаргахаар хамтран ажиллаж буй тухай
- Хойд Америкийн хэвлэл мэдээллийнхэн, тур операторуудад зориулан танилцах аялал зохион байгуулах
- Сурталчилгааг Нейшенал Жеографик "Адвенчер" сэтгүүлд байрлуулах

Уг арга хэмжээнд оролцогсад ҮАЖБ-ын санаачлагуудыг дэмжиж буйгаа илэрхийлэхийн ялдамд оролцох хүсэлтэй байгаа мэдэгдлээ. Арга хэмжээг зохион байгуулсан Браухаус рестораныхан энэхүү боломжийг ашиглан аялал жуулчлалын салбарынханд өөрсдийн комплект хоолны төрөл бүрийн зэсийг танилцуулав.

## Цахим нэг цонхонд холбогдох бэлтгэл ажлын хүрээнд Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын албыг автоматжуулах ажлыг УМХГ эхэллээ

УМХГ ба тус төслийн мэдээлэл технологийн мэргэжилтнүүд хамтран УМХГ-ын Замын-Үүд дэх хилийн мэргэжлийн хяналтын албаны мэргэжилтнүүдэд МТ-ийн сүлжээг ашиглалтанд оруулахад туслах зорилгоор 4 дүгээр сарын 15-20-ны хооронд ажиллаа. Монгол улсын хилийн мэргэжлийн хяналтын албыг автоматжуулах нь тус байгууллагын Цахим нэг цонх (ЦНЦ) хөтөлбөрт нэгдэх ажлын хүрээнд хийж буй төлөвлөгөөт арга хэмжээнүүдийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Уг төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан УМХГ-ын МТ-ийг сайжруулах төлөвлөгөөний эхний шатанд дараах гол зорилтууд багтсан болно. Үүнд УМХГ-ын Замын-Үүдийн мэргэжлийн хяналтын албанд дараах тусалцаа дэмжлэгийг үзүүлэх:

- Албаны дотоод сүлжээг суурилуулж, ашиглалтанд оруулах
- Албадын МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварт үнэлгээ өгч, сургалт явуулах хэрэгцээ, шаардлагыг тогтоох
- Компьютер, тоног төхөөрөмж, программуудын талаар эхний судалгаа хийх (үйлдлийн систем ба хэрэглээний программууд)
- ЦНЦ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уг албыг ГЕГ-ын ГАМАС системд холбох шатлачилсан төлөвлөгөө гаргах



УМХГ, ЭЗБШӨЧ төслийн хамтарсан баг МТ-т үнэлгээ өгөх ажлаа дуусмагц хийсэн дүгнэлтүүдийг багтаасан тайлан гаргаж дараах гол зөвлөмжүүдийг өгсөн болно. Үүнд:

- Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын албаны дотоод сүлжээний дэд бүтцийг өөрчлөн шинэчилж, албаны ерөнхий үйл ажиллагааг стандартчилах хүснэгтэн мэдээллийн үндсэн маягтуудыг ашиглах зорилгоор энгийн файл сервер суурилуулах
- Файл серверт тулгуурлан албаны ажилтнуудын хооронд болон өөр газар байрлаж буй лаборатортай байнгын холбоотой байх үүднээс дотоод сүлжээгээр шуурхай харьцах программыг ашиглалтанд оруулах
- Бүх РС-д вирусаас хамгаалах программыг худалдан авч суурилуулах
- Ажилтнуудын сүлжээний менежментийн ур чадвар зохих түвшин хүртэл сайжрах болтол нэн чухал мэдээллүүдийг алга болохоос сэрэмжлэх үүднээс чухал мэдээлэлтэй компьютерүүдийг вирусээс хамгаалах зорилгоор интернэтэд холбохгүй байх
- Замын-Үүд ба хилийн бусад цэгүүдэд ашиглах хүснэгтэн мэдээллийг хянан шалгаж стандартчилах
- Хүснэгтэн мэдээлэлд тулгуурласан мэдээллүүдийг нэгтгэх үүднээс энгийн мэдээллийн бааз боловсруулж хэрэгжүүлэх
- Сүлжээний менежмент, аюулгүй байдлын чиглэлээр МТ ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шатлачилсан сургалтуудыг зохион байгуулах
- Цахилгаан тасрах тохиолдолд цахилгааны хэлбэлзлийн хамгаалалтыг хангаж, цахилгааныг тодорхой хугацаагаар барих тог баригч UPS бүх компьютерт худалдан авах

МТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хоёр дахь шатны хүрээнд УМХГ-ын МТ-ийн мэргэжилтнүүд уг төслийн тусалцаатайгаар хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудад энгийн файл серверыг ашиглалтанд оруулж удирдахад дэмжлэг үзүүлж, МТ-ийн цуврал сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Иймэрхүү тусалцаа дэмжлэг нь Замын-

Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын албыг автоматжуулахад тус дөхөм болохоос гадна ЦНЦ хөтөлбөрийн хүрээнд уг албыг ГЕГ-ын ГАМАС системд холбох ажлыг эрчимжүүлэх болно.

*Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.  
И-мэйл [fbertoli@epc-chemonics.biz](mailto:fbertoli@epc-chemonics.biz), факс: (976-11) 32 78 25.*